



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 15

Номгон

Хөрөнгийн тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалт, аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн гал түймэр гарсан тухай 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 13 тоот акт, Авто тээврийн үндэсний төвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 29 тоотоор ирүүлсэн хасалтын тодорхойлолтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Аудитын газрын 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 165 тоот албан бичиг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан ажлын хэсгийн 01 дугаартай хурлын тэмдэглэлийн дүгнэлт зэргийг үндэслэн аймгийн Аудитын газрын 22-43 БНХ улсын дугаартай автомашиныг үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассугай.

2. Аймгийн Аудитын газрын шинээр худалдан авсан УАЗ-220692-0330 маркийн D-2890 хөдөлгүүрийн багтаамжтай, 3741100C0483483 арлын дугаартай цагаан саарал өнгийн, 37455 км явсан 80-08 БНХ улсын дугаартай автомашиныг худалдан авсан 18750000 төгрөгөөр байгууллагын үндсэн хөрөнгөд орлого авч бүртгэсүгэй.

3. Албаны автомашиныг хувийн зорилгоор ашиглаж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаагүй зэргээр хариуцлагагүй хандсан аймгийн Аудитын газрын дарга Ё.Сугаррагчаад зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахыг Үндэсний Аудитын газрын дарга /Д.Хүрэлбаатар/-д уламжилсугай.

4. Данс бүртгэлээс хассан, орлого авсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

116191

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР